



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/51-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Ахлах аудитор Н.Алтантуяа Утас: 703333019 Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
3. Аудитын тайлан	8
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Аудитын гол асуудал	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт	12
4.1 Залруулсан алдаа	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

ЖАРГАЛАНТ СУМЫН ИТХ-ЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Ч.САМБУУДОРЖ ТАНАА

2022.02.24 № 81
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Жаргалант сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Жаргалант сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.БАЙГАЛМАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	350,000.00	671,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	350,000.00	671,000.00
35400	Хангамжийн материал	350,000.00	671,000.00
35410	Бичиг хэргийн материал	0.00	321,000.00
35420	Аж ахуйн материал	350,000.00	350,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	9,713,259.72	7,765,407.48
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,713,259.72	7,765,407.48
39200	Биет хөрөнгө	9,713,259.72	7,765,407.48
39203	Авто-тээврийн хэрэгсэл	9,699,260.00	9,699,260.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-1,939,852.20
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,845,233.33	1,845,233.33
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,845,233.33	-1,845,233.33
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,918,054.00	1,918,054.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-1,904,054.28	-1,912,054.32
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	10,063,259.72	8,436,407.48
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,063,259.72	8,436,407.48
51	Засгийн газрын хувь оролцоо	10,063,259.72	8,436,407.48
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	976,000.00	976,000.00
51200	Хуримтлагдсан үр дүн	8,624,837.72	6,997,985.48
51210	Өмнөх үеийн үр дүн	-808,162.40	8,624,837.72
51220	Тайлант үеийн үр дүн	9,433,000.12	-1,626,852.24
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	462,422.00	462,422.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	10,063,259.72	8,436,407.48

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	75,411,860.00	78,125,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,699,260.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,699,260.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,699,260.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,699,260.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	65,712,600.00	78,125,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	420,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	420,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	65,712,600.00	77,705,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	65,712,600.00	77,705,100.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	65,978,859.88	79,751,952.24

Архангай аймгийн Жаргалант сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

21	УРСГАЛ ЗАРДАЛ	65,978,859.88	79,751,952.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	63,854,450.88	77,583,752.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,837,500.00	50,877,400.00
210101	Үндсэн цалин	45,837,500.00	50,124,556.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	752,844.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,188,100.00	6,188,200.00
210201	Тэтгэврийн даатгал	4,354,600.00	4,354,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	458,400.00	458,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	366,700.00	366,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	91,600.00	91,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	916,800.00	916,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	45,280.00
210302	Түлш, халаалт	0.00	45,280.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,646,835.00	6,321,121.00
210401	Бичиг хэрэг	554,800.00	948,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,699,335.00	5,135,121.00
210404	Ном, хэвлэл	392,700.00	238,000.00
2107	Томилолт, зочны зардал	124,000.00	451,300.00
210702	Дотоод албан томилолт	124,000.00	451,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,784,256.00	9,532,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,664,256.00	9,412,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	120,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	273,759.88	4,167,651.24
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	1,799,799.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	420,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	273,759.88	1,947,852.24
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,124,409.00	2,168,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,445,000.00	1,818,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,445,000.00	1,818,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	679,409.00	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	679,409.00	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	350,200.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	350,200.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	9,433,000.12	-1,626,852.24
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	9,433,000.12	-1,626,852.24

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	976,000.00	462,422.00	-808,162.40	630,259.60
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	976,000.00	462,422.00	-808,162.40	630,259.60
4	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
5	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
6	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	9,433,000.12	9,433,000.12
7	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	976,000.00	462,422.00	8,624,837.72	10,063,259.72
8	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	976,000.00	462,422.00	8,624,837.72	10,063,259.72
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	976,000.00	462,422.00	8,624,837.72	10,063,259.72
11	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
12	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
13	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-1,626,852.24	-1,626,852.24
14	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	976,000.00	462,422.00	6,997,985.48	8,436,407.48

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	65,712,600.00	78,125,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	65,712,600.00	78,125,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	420,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	420,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	65,712,600.00	77,705,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	65,712,600.00	77,705,100.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	65,712,600.00	78,125,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	65,712,600.00	78,125,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	63,533,191.00	75,956,900.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,837,500.00	50,877,400.00
210101	Үндсэн цалин	45,837,500.00	45,837,500.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	5,039,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,188,100.00	6,188,200.00
210201	Тэтгэврийн даатгал	4,354,600.00	4,354,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	458,400.00	458,400.00

210203	ҮОМШӨ-ний даатгал	366,700.00	366,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	91,600.00	91,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	916,800.00	916,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,400,000.00	4,500,000.00
210401	Бичиг хэрэг	400,000.00	700,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,500,000.00	3,500,000.00
210404	Ном, хэвлэл	500,000.00	300,000.00
2107	Томилолт, зочны зардал	124,000.00	451,300.00
210702	Дотоод албан томилолт	124,000.00	451,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,983,591.00	11,520,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,863,591.00	11,400,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	120,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	2,420,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	2,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	420,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,179,409.00	2,168,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	1,818,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,818,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	679,409.00	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	679,409.00	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	350,200.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	350,200.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	77,705,100.00	77,354,900.00	350,200.00	99.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	77,705,100.00	77,354,900.00	350,200.00	99.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	75,885,600.00	75,536,900.00	348,700.00	99.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	50,877,400.00	50,877,400.00	0.00	100.0
210101	Үндсэн цалин	45,837,500.00	45,837,500.00	0.00	100.0
210105	Гэрээт ажлын хөлс	5,039,900.00	5,039,900.00	0.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,188,200.00	6,188,200.00	0.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	4,354,600.00	4,354,600.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	458,400.00	458,400.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	366,700.00	366,700.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	91,700.00	91,700.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	916,800.00	916,800.00	0.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	4,500,000.00	4,500,000.00	0.00	100.0
210401	Бичиг хэрэг	700,000.00	700,000.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	3,500,000.00	3,500,000.00	0.00	100.0
210404	Ном, хэвлэл	300,000.00	300,000.00	0.00	100.0

2107	Томилолт, зочны зардал	800,000.00	451,300.00	348,700.00	56.4
210702	Дотоод албан томилолт	800,000.00	451,300.00	348,700.00	56.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,520,000.00	11,520,000.00	0.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,400,000.00	11,400,000.00	0.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	120,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,819,500.00	1,818,000.00	1,500.00	99.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,819,500.00	1,818,000.00	1,500.00	99.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,819,500.00	1,818,000.00	1,500.00	99.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	77,705,100.00	77,354,900.00	350,200.00	99.5
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	77,705,100.00	77,354,900.00	350,200.00	99.5
320001	Орон нутгийн төсвөөс	77,705,100.00	77,354,900.00	350,200.00	99.5
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100.0
610001	Төсвийн байгууллага	1	1		100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	2	2		100.0
620001	Удирдах ажилтан	1	1		100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	1	1		100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	420,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	420,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	420,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	420,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	420,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	420,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	420,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	420,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Жаргалант сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагаас, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Алтантуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Жаргалант сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Жаргалант сумын ИТХ нь Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаар тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа сонгуулийн эрх бүхий иргэдээс сонгогддог, хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, бүрэн эрхийг хамтын удирдлагын зарчмын үндсэн дээр хэрэгжүүлдэг нутгийн өөрөө удирдах байгууллага бөгөөд иргэдэд төрийн үйлчилгээг үзүүлэх, үйл ажиллагааны тасралтгүй удирдлагаар хангах, нутгийн захиргааны шийдвэр гаргах чиг үүрэг бүхий аймаг, сумын ТЕЗ-ийн харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд *“Сумын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх, үйл ажиллагааны тасралтгүй удирдлагаар хангах”* гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд хяналт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалант сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 77.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 0.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 0.6 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 1.6 сая төгрөгөөр буюу 16 хувиар буурч, материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт сая төгрөгөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Б	1	2	3=2-1	
Бараа материал	0.3	0.7	0.4	133.3
Үндсэн хөрөнгө	9.7	7.8	(2.0)	(20.6)
Нийт хөрөнгө	10.0	8.5	(1.6)	(16.0)
Өр төлбөр	-	-		
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	10.0	8.4	(1.6)	(16.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	10.0	8.4	(1.6)	(16.0)

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материал данс өмнөх оноос 133.3 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 0.4 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 6.4 сая төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 6.1 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 0.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос хувиар 20.6 хувиар буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 9.7 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд хөрөнгө нэмэгдээгүй, тайлант хугацаанд байгуулсан 2.0 сая төгрөгийн элэгдлийн дүнгээр буурч, 7.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн буурсан нь тайлант хугацааны үр дүн 1.6 сая төгрөгөөр хасагдсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт сая төгрөгөөр

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	65.7	77.7	12.0
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	0.4	0.4
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9.7	-	(9.7)
Үйл ажиллагааны орлого	75.4	78.1	2.7
Цалин, шимтгэлийн зардал	52.0	57.0	5.0
Бусад бараа үйлчилгээний зардал	6.8	6.8	-
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4.8	9.5	4.7
Бараа үйлчилгээний бусад зардал	0.3	4.2	3.9
Урсгал шилжүүлэг	2.1	2.2	0.1
Үйл ажиллагааны зардал	66.0	79.7	13.7
Үйл ажиллагааны үр дүн	9.4	(1.6)	(11.0)

Санхүүгийн үр дүнгийн тайлангаарх урсгал үйл ажиллагааны санхүүжилт өмнөх оноос 12.0 сая төгрөгөөр буюу 13.8 хувиар өссөн байна. Урсгал санхүүжилтээс 0.4 сая төгрөг хэмнэгдэж, орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 68.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг анх 8.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 77.5 сая төгрөгөөр хянаж баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 77.7 сая төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 77.7 сая төгрөгийн санхүүжилт авч, 77.3 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулан, 0.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төвлөрүүлэх шилжүүлэг нь албан томилолтын зардал хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жил нэмэлт санхүүжилтээр Аймгийн ИТХ-аас ИТХ-ын тэргүүлэгчдийн цахим сургалттай холбоотой 0.4 сая төгрөгийг хүлээн авч, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант онд ИТХ-ын тэргүүлэгчдийн тойрогт ажиллах зардлыг мэдээлэл, сурталчилгааны зардал ангилалд төлөвлөн 9.4 сая төгрөгийг олгосон байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 7 үндсэн зорилтын хүрээнд 40 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг ИТХ-ын даргаас 85.0 хувь гэж үнэлсэн байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 77.7 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 77.3 сая төгрөгийг зарцуулж, 99.5 хувийн биелэлттэй байна

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнгийн талаарх судалгааг авч үзэхэд албан томилолт болон бичиг хэргийн зардлыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан бөгөөд судалгааны бусад асуудлууд хамааралгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж, үр дүнг баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Жаргалант сумын ИТХ нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 150 мэдээллээс 91 мэдээллийг хугацаанд нь, 59 мэдээллийг хугацаа хоцроон байршуулж, төсөв, өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой 12.0 сая төгрөгийн 7 шийдвэрийг шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3- т “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн

6.4.8.”... төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”-ийг 7 хоногийн дотор мэдээлнэ гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг хуулинд заасан хугацаанд тогтмол мэдээлж, зөрчлийг таслан зогсоох, орхигдуулсан мэдээллийг нөхөн байршуулах албан шаардлагыг хүргүүллээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгийн оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 8.3 % буюу 1.7 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 43-р тогтоолыг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, мөн бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй зөрчилд илэрсэнд дотоод хяналтыг тогтмол хэрэгжүүлж үр дүнг тооцож ажиллах 1 заалт бүхий зөвлөмж хүргүүлснийг 80 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудалгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 0.4 сая төгрөгийн алдаа илэрч, санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

4.1 Залруулсан алдаа

Үр дүнгийн тайланд нэмэлт санхүүжилтийн 0.4 сая төгрөгийн орлого, зардлыг дутуу тайлагнасныг аудитын явцад залруулав.

-----oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Жаргалант сумын ИТХ	1	0.4	1	0.4	0	0	0	0	0	0
	Дүн	1	0.4	1	0.4	0	0	0	0	0	0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
2	Жаргалант сумын ИТХ	2	13.7	0	0	0	0	2	13.7	0	0
	Дүн	2	13.7	0	0	0	0	2	13.7	0	0
	Нийт дүн	3	14.1	1	0.4	0	0	2	13.7	0	0